ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр Дугаар ... Улаанбаатар хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 253 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-д доор дурдсан агуулга бүхий дараах заалт нэмсүгэй:

1/2.5 дахь заалт:

“2.5.Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.8-д заасан мэдээллийн системийн мэдээлэлд үндэслэн тухайн жилд энэ журмын 2.1-д заасан төлбөр төлөх үүрэг хүлээх аж ахуйн нэгж, байгууллагыг тодорхойлж, мөн журмын 2.3-т заасан хугацаанд бүртгүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор бүртгэлжүүлэн, төлбөр төлөх үүргийн талаар тухайн аж ахуйн нэгж, байгууллагад цахим, эсхүл цаасан хэлбэрээр мэдэгдэнэ.”

2/3.3.4 дэх заалт:

“3.3.4.энэ журмын 3.1.1-д заасны дагуу нөхөрлөл, хоршоо, төрийн бус байгууллагаар дамжуулан худалдан авсан бол бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг үйлдвэрлэсэн, гүйцэтгэсэн тухайн байгууллагын гишүүн, ажилтан болох хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний жагсаалт, тэдгээрт уг бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээтэй холбогдуулан олгосон цалин хөлс, орлогыг нотлох санхүүгийн баримт.”

3/4.6 дахь заалт:

“4.6.Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага энэ журмын 4.2-т заасан мэдээлэл, тайланг хэлэлцэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.5-д заасны дагуу төлбөрийн хөрөнгөөр тухайн орон нутагт хэрэгжүүлэх хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.”

4/4.7 дахь заалт:

“4.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд зуучлах, ажлын байранд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх, ажил олгогчид тохирох хэрэглэгдэхүүний талаар зөвлөгөө өгөх үйлчилгээг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40.4, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10.2-т заасны дагуу төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.”

5/4.8 дахь заалт:

“4.8.Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-т заасан үүргээ бүрэн биелүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангасан ажлын байранд 1 жилээс доошгүй хугацаанд тогтвортой ажиллуулж байгаа ажил олгогчийн талаарх мэдээллийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийтэд

мэдээлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.4, 15.1.5-д заасан урамшууллын арга хэмжээнд хамруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.”

2.Мөн журмын доор дурдсан заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3.1.1 дэх заалт:

“3.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил үйлчилгээг тэдгээрээс шууд, эсхүл тэдгээр нь нийт гишүүний тал хувиас доошгүйг бүрдүүлсэн нөхөрлөл, хоршоо, эсхүл тэдгээр нь гишүүн, ажилтан нь болох, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар дамжуулан 6 сараас доошгүй хугацаатай гэрээ байгуулж худалдан авсан бол худалдан авсан бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнийн дүнгээр;”

2/4.2 дахь заалт:

“4.2.Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага тухайн жилд төлбөр төлөх үүрэгтэй, үүргээ биелүүлсэн болон биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, төвлөрүүлсэн төлбөрийн хэмжээ, төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, хөнгөлсөн, чөлөөлсөн дүн, аж ахуйн нэгж, байгууллагаас дэмжлэг авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний тоо, төлбөрийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээлэл, тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргаж хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээлэл, тайланг нэгтгэж, Хөдөлмөрийн тухай хуулийн 144.5-д заасны дагуу төлбөр хураалт, зарцуулалт, үр ашгийн талаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлагнана.”

3.Мөн журамд доор дурдсан өөрчлөлт оруулсугай:

1/1.2.2 дахь заалтын “13.2-т” гэснийг “13.2.4-т” гэж;

2/4.3 дахь заалтын “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэж.

3/Журмын нэр: “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх, төвлөрүүлэх” журам гэж өөрчлөх.

4.Энэ тогтоолыг 2027 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ